

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
Аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/202/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn Аудитор: Г.Ичинхорлоо Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com Аудитор Ц.Мөнхтуяа Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgui@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/156
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.НЯМДЭЛГЭР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас ажиллагсдад 27,690.0 мянган төгрөгийн түлээний хөнгөлөлт олгосон нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.
- Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл 27,155.1 мянган төгрөгийг цалингийн бүлгээс шилжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлүүдийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 37,393.8 мянган төгрөгөөр давсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 120,482.7 төгрөг байна.

Аудитын гол асуудал

6724040250

Аудитаар нийт 60,852.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 28,122.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 32,729.6 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг өглөө.

Бусад асуудлын хэсэг

Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хариуцсан нягтлан бодогч удаа дараа солигдож, тогтвор суурьшилгүй байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  АЭРДЭНЗБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	261,844,009.27	344,359,035.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,210,901.00	120,482,695.68
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	72,210,901.00	120,482,695.68
31210	Төгрөг	72,210,901.00	120,482,695.68
31211	Төрийн сангийн харилцах	72,210,901.00	120,482,695.68
33	АВЛАГА	9,872,000.00	-
33500	Бусад авлага	9,872,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	9,872,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	179,761,108.27	223,876,339.37
35100	Түүхий эд материал	3,294,969.00	3,826,169.00
35130	Эм боох материал	3,294,969.00	3,826,169.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,918,953.00	6,175,185.10
35400	Хангамжийн материал	174,547,186.27	213,874,985.27
35410	Бичиг хэргийн материал	3,048,000.00	1,171,940.00
35420	Аж ахуйн материал	135,515,641.23	153,706,255.23
35440	Түлш, шатах тослох материал	840,000.04	1,390,000.04
35450	Барилгын засварын материал	2,782,150.00	6,747,150.00
35460	Хүнсний материал	30,359,135.00	48,585,141.00
35470	Бусад хангамжийн материал	2,002,260.00	2,274,499.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,505,489,176.02	2,488,113,103.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,505,489,176.02	2,488,113,103.22
39200	Биет хөрөнгө	2,468,905,742.77	2,451,579,670.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,569,577,833.00	2,597,022,783.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-300,702,237.58	-394,046,681.98
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	274,783,727.24	350,153,727.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-168,866,061.11	-197,122,710.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,692,559.43	158,563,759.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,382,267.54	-98,847,280.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,409,775.66	25,409,775.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	-25,409,775.66	-25,409,775.66
39217	Ном	32,802,189.33	35,856,073.53
39300	Биет бус хөрөнгө	36,583,433.25	36,533,433.21
39301	Программ хангамж	1,604,000.00	1,604,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,458,166.75	-1,508,166.79
39303	Бусад биет бус хөрөнгө	36,437,600.00	36,437,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,767,333,185.29	2,832,472,138.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,541,125.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,541,125.00
41300	Өглөг	-	1,541,125.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,125.00
41360	Бусад өглөг	-	1,540,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,540,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,767,333,185.29	2,830,931,013.27
51	Засгийн газрын хувь оролцоо	2,767,333,185.29	2,830,931,013.27
51100	Засгийн газрын оруулсан капитал	759,822,360.46	759,822,360.46
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	759,822,360.46	759,822,360.46
51200	Хуримтлагдсан үр дүн	1,574,444,340.59	1,638,042,168.57
51210	Өмнөх үеийн үр дүн	1,522,742,879.37	1,574,444,340.59
51220	Тайлант үеийн үр дүн	51,701,461.22	63,597,827.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,066,484.24	433,066,484.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,767,333,185.29	2,832,472,138.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,602,927,455.77	2,005,395,381.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,131,955.77	93,886,881.30
120	Нийтлэг татварын бус орлого	36,310,956.77	93,886,881.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,347,300.00	3,999,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,347,300.00	3,824,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33,963,656.77	66,558,034.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	23,329,647.10
122	Тусламжийн орлого	15,820,999.00	
122001	Хандив тусламж /дотоод/	15,820,999.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,795,500.00	1,911,508,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,277,651,200.00	1,793,844,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,651,200.00	1,793,844,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,144,300.00	117,664,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,144,300.00	117,664,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,551,225,994.55	1,941,797,553.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,551,225,994.55	1,941,797,553.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,489,273,578.55	1,864,334,279.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	905,097,291.00	1,221,374,329.86
210101	Үндсэн цалин	717,403,355.00	1,221,374,329.86
210102	Нэмэгдэл	164,451,299.00	-
210104	Урамшуулал	23,242,637.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,029,955.00	120,180,635.94
210201	Тэтгэврийн даатгал	76,338,949.46	72,780,511.82
210202	Тэтгэмжийн даатгал	8,981,046.67	9,270,750.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,184,837.31	10,587,700.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,794,900.85	2,301,187.30
210205	Эрүүл мэндийн даатгал	17,730,220.71	25,240,485.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,947,372.00	210,981,005.57
210301	Гэрэл, цахилгаан	8,997,548.00	12,086,121.57
210302	Түлш, халаалт	197,449,824.00	198,694,884.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,699,404.00	29,982,101.00
210401	Бичиг хэрэг	6,284,154.00	18,319,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,559,460.00	5,595,375.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,855,790.00	6,067,126.00
2105	Нормативт зардал	74,814,670.00	97,886,300.00
210502	Хоол, хүнс	74,814,670.00	97,886,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,858,100.00	25,115,100.00
210604	Урсгал засвар	17,858,100.00	25,115,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,062,300.00	9,337,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,312,300.00	2,563,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,750,000.00	6,774,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,764,486.55	149,477,007.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,284,500.00	15,810,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,120,000.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	127,359,986.55	133,116,107.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,952,416.00	77,463,273.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,418,624.00	77,463,079.52
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,418,624.00	63,656,850.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	13,806,229.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,533,792.00	194.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,533,792.00	194.43
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	51,701,461.22	63,597,827.98
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	51,701,461.22	63,597,827.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,553,142,800.00	1,914,517,824.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,347,300.00	3,009,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,347,300.00	3,009,324.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,347,300.00	3,009,324.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,347,300.00	3,009,324.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,795,500.00	1,911,508,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,277,651,200.00	1,686,527,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,651,200.00	1,686,527,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,144,300.00	224,981,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,144,300.00	224,981,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,453,062,899.00	1,828,476,029.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,453,062,899.00	1,828,476,029.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,376,878,783.00	1,734,952,735.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	905,097,291.00	1,225,404,638.75
210101	Үндсэн цалин	728,679,175.00	851,055,454.18
210102	Нэмэгдэл	159,820,692.00	323,650,224.42
210104	Урамшуулал	16,597,424.00	50,698,960.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,029,955.00	116,150,327.05
210201	Тэтгэврийн даатгал	91,934,692.24	84,120,839.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,023,813.86	8,089,645.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,019,051.12	6,392,016.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,762.74	1,593,383.85
210205	Эрүүл мэндийн даатгал	10,047,635.04	15,954,441.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,947,372.00	209,981,005.57
210301	Гэрэл, цахилгаан	8,997,548.00	12,086,121.57
210302	Түлш, халаалт	197,449,824.00	197,447,684.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	447,200.00
2105	Нормативт зардал	84,165,655.00	101,718,660.00
210502	Хоол, хүнс	84,165,655.00	101,718,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,052,300.00	10,055,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,312,300.00	1,573,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,740,000.00	8,481,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,586,210.00	56,643,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,925,960.00	43,140,204.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,660,250.00	13,502,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,184,116.00	93,523,293.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,650,324.00	93,523,099.52
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,650,324.00	81,396,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,127,099.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,533,792.00	194.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,533,792.00	194.43

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	100,079,901.00	86,041,794.68
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,869,000.00	37,770,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,869,000.00	37,770,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,869,000.00	37,770,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,869,000.00	37,770,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,869,000.00	-37,770,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	72,210,901.00	48,271,794.68
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	72,210,901.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,210,901.00	120,482,695.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,522,742,879.37	2,715,631,724.07
Тайлант үеийн үр дүн	-	-	51,701,461.22	51,701,461.22
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,574,444,340.59	2,767,333,185.29
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,574,444,340.59	2,767,333,185.29
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,574,444,340.59	2,767,333,185.29
Тайлант үеийн үр дүн	-	-	63,597,827.98	63,597,827.98
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,638,042,168.57	2,830,931,013.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,760,246,700.00	1,641,264,829.32	93.24	118,981,870.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,760,246,700.00	1,641,264,829.32	93.24	118,981,870.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,666,723,600.00	1,547,741,729.80	92.86	118,981,870.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,288,362,700.00	1,225,404,638.75	95.11	62,958,061.25
210101	Үндсэн цалин	875,037,800.00	851,055,454.18	97.26	23,982,345.82
210102	Нэмэгдэл	352,040,000.00	323,650,224.42	91.94	28,389,775.58
210104	Урамшуулал	61,284,900.00	50,698,960.15	82.73	10,585,939.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,045,500.00	116,150,327.05	72.12	44,895,172.95
210201	Тэтгэврийн даатгал	109,511,000.00	84,120,839.51	76.81	25,390,160.49
210202	Тэтгэмжийн даатгал	12,883,600.00	8,089,645.70	62.79	4,793,954.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,307,000.00	6,392,016.59	62.02	3,914,983.41
210204	Ажилгүйдлийн даатгал	2,576,700.00	1,593,383.85	61.84	983,316.15
210205	Эрүүл мэндийн даатгал	25,767,200.00	15,954,441.40	61.92	9,812,758.60
2105	Нормативт зардал	101,718,800.00	101,718,660.00	100.00	140.00
210502	Хоол, хүнс	101,718,800.00	101,718,660.00	100.00	140.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,902,500.00	10,055,000.00	92.23	847,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,573,900.00	1,573,900.00	100.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,328,600.00	8,481,100.00	90.92	847,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,694,100.00	94,413,104.00	90.18	10,280,996.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,701,200.00	80,420,204.00	88.66	10,280,996.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,992,900.00	13,992,900.00	100.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,523,100.00	93,523,099.52	100.00	0.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,523,100.00	93,523,099.52	100.00	0.48
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,396,000.00	81,396,000.00	100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,127,100.00	12,127,099.52	100.00	0.48
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,760,246,700.00	1,689,536,624.00	95.98	70,710,076.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,686,527,300.00	1,686,527,300.00	100.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,686,527,300.00	1,686,527,300.00	100.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	73,719,400.00	3,009,324.00	4.08	70,710,076.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,538,900.00	3,009,324.00	195.55	-1,470,424.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	72,180,500.00	0	0.00	72,180,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	72,210,901.00		-72,210,901.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	120,482,695.68		-120,482,695.68

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,981,200.00	209,981,005.57	100.00	194.43
210301	Гэрэл, цахилгаан	12,086,300.00	12,086,121.57	100.00	178.43
210302	Түлш, халаалт	197,447,700.00	197,447,684.00	100.00	16.00
210303	Цэвэр, бохир ус	447,200.00	447,200.00	100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	100.00	-
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	100.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43
320001	Орон нутгийн төсвөөс	224,981,200.00	224,981,005.57	100.00	194.43

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 663,489.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 60,852.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 28,122.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 32,729.5 мянган төгрөгийн 4 зөвлөмж
- Нийцлийн аудитад хамааралтай 602,636.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг Түнэл сумын сургуулийн захирал, нягтлан бодогчид өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 60,852.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 21,834.1 мянган төгрөгөөс 39,018.2 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Цалингийн зардлаас ажиллагсдад 27,690.0 мянган төгрөгийн түлээний үнийн хөнгөлөлт олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтанд 432.8 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7 “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.” заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 153 нэр төрлийн 229,346.2 мянган төгрөгийн 944 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 27,055.2 мянган төгрөгийн ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн, танхимаас гадуурх сургалтын зардлаас 1,800.0 мянган төгрөгийн багш нарын сургалтын төлбөрийг төлсөн, тоног төхөөрөмжийн нөхөн

хангалтын зардлаас 3,657.8 мянган төгрөгийн материал худалдаж авсан, урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөрийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;” заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар, аргачлал”, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын хавсралтад заасан зориулалт, арга хэмжээтэй нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургуулийн аудит хийлгэхээр ирүүлсэн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнийг шалгаж үзэхэд санхүүгийн тайлангийн тодруулга, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5 “санхүүгийн тайлангийн тодруулга”, 54.5.3 “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүнээр бүрэн бэлтгэдэг байх.

4. Төлбөр, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элбэгмөрөн ХХК-ийн тооцоог анхан шатны баримтаас ерөнхий журнал уруу хөөж шалгахад 216.6 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын тооцоог тухай бүр хийж, төлбөр тооцоог хянаж шилжүүлэх

5. Шилэндансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 602,636.9 мянган төгрөгийн 20 мэдээллийг байршуулаагүй байгаа нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой

байх” батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас түлээний хөнгөлөлт олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал олгосон	1	28,122.8	1	28,122.8				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байна.	1	-					1	-
Зардлыг зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна.	1	32,513.0					1	32,513.0
Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн дутуу	1	-					1	-
Бэлтгэн нийлүүлэгчид төлбөр тооцоог илүү шилжүүлсэн	1	216.6					1	216.6
Дүн	5	60,852.4	1	28,122.8		-	4	32,729.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20 мэдээлэл оруулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	602,636.9					1	602,636.9
Дүн	1	602,636.9					1	602,636.9

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй						
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 47/А.2270439/ХӨА-2024/
202/ХА-СМ.А-ТМШЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалингийн зардлаас ажиллагсдад 27,690,000/хорин долоон сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгийн түлээний үнийн хөнгөлөлт, сахилгын шийтгэлтэй ажилтан А.Хишигмаад 432,820 /дөрвөн зуун гучин хоёр мянга найман зуун хорь/ төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

- Сахилгын шийтгэлтэй ажилтан А.Хишигмаад олгосон улирлын үр дүнгийн урамшуулал 432,820 /дөрвөн зуун гучин хоёр мянга найман зуун хорь/ төгрөг болон цалингийн зардлаас олгосон түлээний үнийн хөнгөлөлт 27,690,000 /хорин долоон сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий ажиллагсдаас суутган тооцож Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Нямдэлгэр, нягтлан бодогч Ч.Хорлоо нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
“ИХЭР МӨРӨН АУДИТ” ХХК
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724030154

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн
 47/12220439/2024-2024/202/221-0111-1113
 төлбөрийн актын хавсралт

1720090

0605

ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Овог	Нэр	Түлээний хөнгөлөлт
1	Онолбаатар	Нармандах	390,000.00
2	Далайжаргал	Цэрэндулам	390,000.00
3	Батчулуун	Энхтуул	390,000.00
4	Буяннэмэх	Пүрэвсүрэн	390,000.00
5	Түмэндэмбэрэл	Отгончулуу	390,000.00
6	Гомбосүрэн	Оюунжаргал	390,000.00
7	Чимэддорж	Мөнхбат	390,000.00
8	Самбалхүндэв	Оюунцэцэг	390,000.00
9	Доржготов	Мягмарнаран	390,000.00
10	Төмөр	Бат-амгалан	390,000.00
11	Долгор	Оюундалай	390,000.00
12	Дамбаравжаа	Өлзий-орших	390,000.00
13	Доржсүрэн	Отгонбилэг	390,000.00
14	Норовсамбуу	Пүрэвжав	390,000.00
15	Банзай	Цогт-эрдэнэ	390,000.00
16	Пүрэвдорж	Бямбадалай	390,000.00
17	Дамбий	Өлзийдүүрэн	390,000.00
18	Пүрэвдалай	Пүрэвсүрэн	390,000.00
19	Долгор	Оюунтуяа	390,000.00
20	Загдхорол	Өнөрзаяа	390,000.00
21	Ганболд	Энх-үйлс	390,000.00
22	Даваадорж	Нарангэрэл	390,000.00
23	Бямба	Нэргүй	390,000.00
24	Хишигбат	Лхагважав	390,000.00
25	Хүрэлчулуун	Саранцэцэг	390,000.00
26	Чимэддорж	Баасанжаргал	390,000.00
27	Баттөмөр	Удаанжаргал	390,000.00
28	Аюуш	Хишигмаа	390,000.00
29	Дэндэвдорж	Зул	390,000.00
30	Лхамсүрэн	Түмэнжаргал	390,000.00
31	Бадам	Гэрэлтуяа	390,000.00
32	Дамдинсүрэн	Эрдэнэцэцэг	390,000.00
33	Аюуш	Мягмардорж	390,000.00
34	Норовсамбуу	Гүнсмаа	390,000.00
35	Мянганбаяр	Пүрэвсэлэнгэ	390,000.00
36	Ганбаатар	Дашмаа	390,000.00
37	Нямдаваа	Лхагвасүрэн	390,000.00
38	Дампил	Энхдэмбэрэл	390,000.00
39	Бат-эрдэнэ	Дэжидням	390,000.00
40	Даяндорж	Нансалмаа	390,000.00
41	Дашдаваа	Алтаншагай	390,000.00
42	Даваадорж	Ичинноров	390,000.00
43	Дамба	Өнөржаргал	390,000.00
44	Зоёо	Төртогтох	390,000.00
45	Оросоо	Нямчимэг	390,000.00
46	Даваа-очир	Санжаажамц	390,000.00
47	Гэндэн	Тэмүүлэн	390,000.00
48	Бямбадалай	Бадамгарав	390,000.00
49	Даваанамжил	Өлзийсайхан	390,000.00
50	Бадарч	Хишигжаргал	390,000.00

51	Банзай	Цолмонгэрэл	390,000.00
52	Цогт	Нандинцэцэг	390,000.00
53	Батмөнх	Отгонжаргал	390,000.00
54	Готов	Бямбасүрэн	390,000.00
55	Бямбадорж	Өлзийбуян	390,000.00
56	Дулам	Баасанжав	390,000.00
57	Зооёо	Эрдэнэлүрэв	390,000.00
58	Отгондаваа	Давааням	390,000.00
59	Батчулуун	Энхманлай	390,000.00
60	Уянга	Чулуунхүү	390,000.00
61	Гаваа	Чанцалням	390,000.00
62	Ганболд	Ган-эрдэнэ	390,000.00
63	Төмөрбаатар	Мөрөнгоо	390,000.00
64	Жигжидсүрэн	Хонгормаа	390,000.00
65	Шарав	Оюунаа	390,000.00
66	Дамдинжав	Даариймаа	390,000.00
67	Цэдэвдамба	Осоржмаа	390,000.00
68	Намсрай	Баасанжав	390,000.00
69	Жамбалжав	Наранцэцэг	390,000.00
70	Дашвандан	Энхцэцэг	390,000.00
71	Чулуун	Нямаа	390,000.00
Дүн			27,690,000



0000000